



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 16/11

Арвайхээр сум

Нийтийн сонсгол зохион байгуулах тухай

Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.3, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.4, 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2026 оны 02 дугаар улиралд зохион байгуулагдах нийтийн сонсголын товыг доор дурдсанаар тогтоосугай. Үүнд:

- 1.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай” 22/02 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийх ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагийн 09:00 цагт;
- 1.2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, үр дүнд хийх төсвийн хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагийн 14:00 цагт.

2. Дээрх хоёр сонсголыг даргалагчаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Төсөв, эдийн засгийн бодлогын хорооны гишүүн Д.Амартүвшинг томилсугай.

3. Нийтийн сонсголын товыг цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх, бусад холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг хариуцан зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (С.Ундрах)-нд даалгасугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ